БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2021/5/СТА-ТШЗ**


Газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342315 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342970 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Энхтөр

Утас: 70342970 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2021 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ........ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 11
3. Аудитын тайлан ........ 11
3.1. Ерөнхий зүйл ........ 11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ........ 11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ........ 12
3.4. Материаллаг байдал ........ 12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ........ 14
3.7. Шилэн дансны мэдээлэл ........ 15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15
3.9. Аудитын илрүүлэлт ........ 16
Залруулсан алдаа ........ 16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ........ 16
Аудитын зөвлөмж ........ 16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ........ 16
4. Менежментийн захидал ........ 17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ........ 18

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.01 № 23

танай ____________-ны №______________т

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Ү.БЯМБАСҮРЭН ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020048

**Үүрэг, хариуцлага**

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **48,294,398.56** | **52,836,360.56** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 48,294,398.56 | 52,836,360.56 |
| **351** | **Түүхий эд материал** | 8,093,920.00 | 7,780,780.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 8,093,920.00 | 7,780,780.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 40,200,478.56 | 45,055,580.56 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 14,090,066.61 | 14,662,666.61 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,222,923.95 | 26,591,423.95 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 212,000.00 | 372,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,675,488.00 | 3,180,940.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 00.00 | 248,550.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **513,274,532.15** | **494,057,834.50** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 513,274,532.15 | 494,057,834.50 |
| **392** | **Биет хөрөнгө** | 493,186,532.00 | 474,470,501.34 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 409,423,075.72 | 409,423,075.72 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -14,503,926.12 | -21,755,889.18 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 90,491,750.00 | 90,491,750.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -83,291,750.04 | -84,091,750.08 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 317,034,314.07 | 331,468,818.07 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -239,851,527.86 | -263,918,200.22 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 35,264,872.41 | 37,049,572.41 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -21,380,276.18 | -24,196,875.38 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 20,088,000.15 | 19,587,333.16 |
| 39301 | Програм хангамж | 3,210,000.00 | 3,210,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,591,999.85 | -3,092,666.84 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 19,470,000.00 | 19,470,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **561,568,930.71** | **546,894,195.06** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **561,568,930.71** | **546,894,195.06** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 561,568,930.71 | 546,894,195.06 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 427,169,483.31 | 427,169,483.31 |
| 51101 | Өмч: - төрийн | 427,169,483.31 | 427,169,483.31 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 36,750,260.83 | 22,075,525.18 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 36,750,260.83 | 36,750,260.83 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | -14,674,735.65 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 97,649,186.57 | 97,649,186.57 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **561,568,930.71** | **546,894,195.06** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **659,307,670.29** | **642,059,240.08** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **42,635,353.00** | **31,751,042.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 42,635,353.00 | 31,751,042.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 42,635,353.00 | 31,751,042.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,901,453.00 | 30,373,042.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 21,733,900.00 | 1,378,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **170,700,617.29** | **104,054,698.08** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 445,971,700.00 | 506,253,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 132,545,117.29 | 67,899,411.38 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 132,545,117.29 | 65,899,411.38 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 28,850,000.00 | 30,300,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,850,000.00 | 30,300,000.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 9,305,500.00 | 5,855,286.70 |
| 133003 | Хөрөнгийн | 9,305,500.00 | 5,855,286.70 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **662,563,774.21** | **656,733,975.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **662,563,774.21** | **656,733,975.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 536,291,374.92 | 551,348,489.81 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 322,208,461.00 | 380,220,293.36 |
| 210101 | Үндсэн цалин | 254,853,754.00 | 282,912,010.44 |
| 210102 | Нэмэгдэл | 51,053,363.00 | 79,354,133.39 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,441,097.00 | 8,996,500.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6,860,247.00 | 8,957,649.53 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,692,970.00 | 48,250,697.10 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,011,585.00 | 34,503,988.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,837,145.00 | 3,343,862.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,571,336.00 | 1,928,986.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 843,600.00 | 834,984.57 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,429,304.00 | 7,638,874.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,700,923.00 | 28,327,372.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,693,853.00 | 2,440,130.00 |
| 210302 | Түлш, халаалт | 25,238,400.00 | 25,238,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 768,670.00 | 648,842.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,096,541.00 | 23,581,073.10 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,139,661.00 | 12,099,716.70 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,805,820.00 | 10,143,712.40 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 513,200.00 | 433,744.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 637,860.00 | 903,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 305,100.00 | 328,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 305,100.00 | 328,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 784,300.00 | 165,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 784,300.00 | 165,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,224,200.00 | 3,892,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,224,200.00 | 3,892,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 206,100.00 | 235,552.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 57,600.00 | 87,052.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,500.00 | 148,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 127,072,779.92 | 66,346,902.25 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 76,271,895.00 | 30,911,000.60 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 50,800,884.92 | 35,435,901.65 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 126,272,399.29 | 105,385,485.92 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,564,000.00 | 2,052,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,234,900.00 | 2,052,600.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 18,165,326.00 | 29,361,047.54 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,165,326.00 | 29,361,047.54 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 364,777.00 | 1,499,628.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 364,777.00 | 1,499,628.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 88,178,296.29 | 72,472,210.38 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 88,178,296.29 | 30,373,042.00 |
| 213505 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | 00.00 | 42,099,168.38 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-3,256,103.92** | **-14,674,735.65** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-3,256,103.92** | **-14,674,735.65** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **628,268,270.29** | **634,825,953.38** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **20,901,453.00** | **30,373,042.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 20,901,453.00 | 30,373,042.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 20,901,453.00 | 30,373,042.00 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,901,453.00 | 30,373,042.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **607,366,817.29** | **604,452,911.38** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 445,971,700.00 | 506,253,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 132,545,117.29 | 67,899,411.38 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 132,545,117.29 | 65,899,411.38 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 28,850,000.00 | 30,300,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,850,000.00 | 30,300,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **607,296,670.29** | **618,606,749.38** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **607,296,670.29** | **618,606,749.38** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **481,024,271.00** | **513,221,263.46** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 322,022,661.00 | 380,220,293.36 |
| 210101 | Үндсэн цалин | 254,853,754.00 | 282,912,010.44 |
| 210102 | Нэмэгдэл | 51,053,363.00 | 79,354,133.39 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,441,097.00 | 8,996,500.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6,674,447.00 | 8,957,649.53 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,692,970.00 | 48,250,697.10 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,011,585.00 | 34,503,988.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,837,145.00 | 3,343,862.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,571,336.00 | 1,928,986.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 843,600.00 | 834,984.57 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,429,304.00 | 7,638,874.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,700,923.00 | 28,327,372.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,693,853.00 | 2,440,130.00 |
| 210302 | Түлш, халаалт | 25,238,400.00 | 25,238,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 768,670.00 | 648,842.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,824,000.00 | 18,254,334.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,145,500.00 | 4,759,890.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,805,800.00 | 11,820,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 513,200.00 | 433,744.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,359,500.00 | 1,240,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 396,000.00 | 328,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 396,000.00 | 328,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 784,300.00 | 473,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 784,300.00 | 473,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,375,200.00 | 3,892,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,375,200.00 | 3,892,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 206,100.00 | 235,552.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 57,600.00 | 87,052.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,500.00 | 148,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 80,022,117.00 | 33,238,315.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 80,022,117.00 | 33,238,315.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **126,272,399.29** | **105,385,485.92** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,564,000.00 | 2,052,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,234,900.00 | 2,052,600.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 18,165,326.00 | 29,361,047.54 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,165,326.00 | 29,361,047.54 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 364,777.00 | 1,499,628.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 364,777.00 | 1,499,628.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 88,178,296.29 | 72,472,210.38 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 88,178,296.29 | 30,373,042.00 |
| 213505 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | 00.00 | 42,099,168.38 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **20,971,600.00** | **16,219,204.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **20,971,600.00** | **16,219,204.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **20,971,600.00** | **16,219,204.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 20,971,600.00 | 16,219,204.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 3,771,600.00 | 16,219,204.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-20,971,600.00** | **-16,219,204.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **427,169,483.31** | **97,649,186.57** | **36,750,260.83** | **00.00** | 561,568,930.71 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **427,169,483.31** | **97,649,186.57** | **36,750,260.83** | **00.00** | 561,568,930.71 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **427,169,483.31** | **97,649,186.57** | **36,750,260.83** | **00.00** | 561,568,930.71 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -14,674,735.65 | 00.00 | -14,674,735.65 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **427,169,483.31** | **97,649,186.57** | **22,075,525.18** | **00.00** | 546,894,195.06 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 00.00 | 00.00 | 536,553,500.00 | 503,908,124.46 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 00.00 | 00.00 | 536,553,500.00 | 503,908,124.46 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 00.00 | 00.00 | 534,313,500.00 | 501,855,524.46 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 00.00 | 00.00 | 380,275,400.00 | 380,220,293.36 |
| 210101 | Үндсэн цалин | 00.00 | 00.00 | 283,109,100.00 | 282,912,010.44 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 00.00 | 74,933,500.00 | 79,354,133.39 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 | 10,158,900.00 | 8,996,500.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 00.00 | 12,073,900.00 | 8,957,649.53 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 00.00 | 00.00 | 51,337,200.00 | 48,250,697.10 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 00.00 | 00.00 | 36,126,100.00 | 34,503,988.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 3,802,800.00 | 3,343,862.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 3,042,200.00 | 1,928,986.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 760,600.00 | 834,984.57 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 7,605,500.00 | 7,638,874.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 00.00 | 00.00 | 29,488,400.00 | 28,327,372.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 00.00 | 2,950,000.00 | 2,440,130.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 00.00 | 25,638,400.00 | 25,238,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 00.00 | 900,000.00 | 648,842.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 00.00 | 00.00 | 19,962,800.00 | 18,254,334.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 00.00 | 00.00 | 5,194,500.00 | 4,759,890.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 00.00 | 12,895,600.00 | 11,820,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 00.00 | 513,200.00 | 433,744.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 00.00 | 1,359,500.00 | 1,240,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 00.00 | 00.00 | 396,000.00 | 328,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 00.00 | 396,000.00 | 328,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 00.00 | 811,600.00 | 473,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 00.00 | 811,600.00 | 473,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 00.00 | 16,060,600.00 | 3,892,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 00.00 | 16,060,600.00 | 3,892,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 00.00 | 00.00 | 242,500.00 | 235,552.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 00.00 | 94,000.00 | 87,052.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 00.00 | 148,500.00 | 148,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 0.00 | 35739000.00 | 21872576.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 00.00 | 35,739,000.00 | 21,872,576.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 0.00 | 2240000.00 | 2052600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 | 2,240,000.00 | 2,052,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 00.00 | 2,240,000.00 | 2,052,600.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **00.00** | **00.00** | **1,784,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 00.00 | 00.00 | 1,784,700.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 00.00 | 00.00 | 00.00 | 1,784,700.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 00.00 | 00.00 | 536,553,500.00 | 566,263,266.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 00.00 | 506,253,500.00 | 506,253,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 00.00 | 506,253,500.00 | 506,253,500.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 00.00 | 30,300,000.00 | 30,300,000.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 00.00 | 00.00 | 30,300,000.00 | 30,300,000.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 00.00 | 00.00 | 00.00 | 29,709,766.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 00.00 | 00.00 | 29,709,766.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 00.00 | 00.00 | 1,020.00 | 58,301.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 00.00 | 00.00 | 555.00 | 7,878.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 00.00 | 00.00 | 455.00 | 4,545.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620003 | Үйлчлэх ажилтан | 00.00 | 00.00 | 10.00 | 45,878.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **13,525,639.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **13,525,639.00** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 13,525,639.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 13525639.00 | |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 13,525,639.00 | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **12,274,604.00** | |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 12,274,604.00 | |
| 223001 | Бусад хөрөнгө | | 12,274,604.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 67899411.38 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 67,899,411.38 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 65,899,411.38 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2,000,000.00 | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ү.Бямбасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд тээвэр шатахуун, томилолтын дансны батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж дахин давтахгүй байх талаар зөвлөмж өгч менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 01 дүгээр сарын 28–ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Энхтөр хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01/33 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Газрын харилцаа, барилгын салбарын багц хуулиудыг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт үр дүнтэй зохион байгуулж, газрын шинэтгэлийн бодлогыг эрчимжүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, барилга хот төлөвлөлтийн үйл ажиллагааг орчин үеийн

мэдээллийн технологид түшиглэн иргэдийн амьжиргааны төвшинг сайжруулахад чиглэсэн үйлчилгээг нээлттэй, шуурхай үзүүлэх төрийн байгууллага байна” гэсэн зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Газрын зохион байгуулалт
- Барилгын техник хяналт

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Газрын тухай хууль
- Барилгын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Бусад холбогдох хууль тогтоомж

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 850.0 мянган төгрөгийн тээвэр шатахуун, томилолттой холбоотой 2 зөвлөмж өгсөн байна.

850.0 мянган төгрөгийн зөвлөмжийн гүйцэтгэлийг Увс аймаг руу явж туршлага судлах болон зөвлөгөөний үр дүнгээр гарсан ажлын гүйцэтгэл тайланг тооцож үнэлж зөвлөмжийн хариу ирүүлэх.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар нь Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудит хийхэд зөрчил илрээгүй, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн мэдээлж ажилласан байна.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн орлого сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын 642059240.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6420592.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14674.7 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 48294398.56 | 52836360.56 | -4541962 |
| Үндсэн хөрөнгө | 513274532.15 | 494057834.50 | 19216697.65 |
| **Нийт хөрөнгө** | 561568930.71 | 546894195.06 | 14674735.65 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 561568930.71 | 546894195.06 | 14674735.65 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 561568930.71 | 546894195.06 | 14674735.65 |

Бараа материалын дансны үлдэгдэл 52836.7 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 4541.9 мянган төгрөгөөр өссөн нь тээвэр шатахуун, бичиг хэрэг, аж ахуйн материал, сэлбэг хэрэгслийн материалын үлдэгдэлтэй байгаа нь шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Энэ нь тайлант онд үлдэгдлээр үлдсэн буюу дараа оны нэг дүгээр сард ашиглах бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл болон аж ахуйн материал нөөцөлсөн байна. Оны эхэнд санхүүжилт сарын сүүлээр орж ирдэг тул нөөцлөх шаардлагатай гэж үзсэн байна. Оны эцэст 1445.3 мянган төгрөгийн шатахууны худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь оны эхэн буюу нэгдүгээр сарын санхүүжилт сарын сүүлээр орж ирдэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 494057.8 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 19216.7 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл шалтгаалжээ. Тайлант жилд шинээр 2 мэргэжилтэн ажилд орсонтой холбоотойгоор сандал ширээ, компьютер мөн байгууллагын үйл ажиллагаанд том оврын олон үйлдэлт принтер урсгал төсвийн худалдан авалтаар 16219.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөнд үнэ төлбөргүй шилжүүлсэн, акталсан хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.0 үлдэгдэлтэй өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 546894.2 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 14674.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн шалтгаалжээ. Энэ нь үлдсэн үйл ажиллагааны орлого, зарлага буурсантай холбоотой байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 17248.4 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэлт санхүүжилт, үнэ төлбөргүй орлого байна. Энэ нь өмнөх онд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө буурсан, газар зохион байгуулалтын сургалтын санхүүжилт, техник хяналтын орлого зэрэг орлого буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 5829.8 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн элэгдэл зардал байна. Энэ нь 0 үлдэгдэлтэй үндсэн хөрөнгө буюу авто машинаас элэгдэл тооцогдоогүй дахин үнэлсэн шалтгаанаас нийт зардал буурсан үзүүлэлтэй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга хийсэн гүйлгээ байхгүй байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 610638.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 610638.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 74082.0 мянган төгрөгөөр бууруулж 536556.5 мянган төгрөгөөр баталсан байна. Бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх шалтгаанаар үндсэн цалингийн данснаас хасаж буюу буурч ирсэн байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэхээр баталсан хөтөлбөр, арга хэмжээ байхгүй байна.

Гүйцэтгэлээр улсын /орон нутгийн/ төсвөөс 642059.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 30373.04 мянган төгрөг, нийт 98272.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 656733.9 мянган төгрөгийг зарцуулж 30860.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 656733.9 мянган төгрөг буюу 84.3 хувьтай байгаа нь үндсэн дансны хэмнэл зардлыг 30860.7 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн зардлыг 42000.0 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагаанаас 30000.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь үндсэн үйл ажиллагааны орлого, нэмэлт санхүүжилтийн орлого, үйл ажиллагааны орлогоос дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Улсын /орон нутгийн/ төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 70000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 103260.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 47.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт 2* Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөв | Гүйц | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Улсын төсөв | | 29361.0 | 29361.0 | 100 |
| Орон нутаг | | 1499.6 | 1499.6 | 100 |
| ГЗБГЗЗГ-ын төвлөрүүлэх | 70000.0 | 72400.0 | 2400.0 | 3.3 |
| **Нийт дүн** | 70000.0 | 103260 | 33260.6 | 47.5 |

Улсын төсөвт 29361.0 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 1499.6 мянган төгрөг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын төвлөрүүлэх орлогын дансанд 70000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэх төлөвлөгөөнөөс 2400.0 мянган төгрөгийг давуулан биелүүлж нийт 103260.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Барилгын техник хяналтын орлогоор 65099.4 мянга, аймгийн Засаг даргын тамгын газраас шагнал урамшуулал 800.0 мянга, ГЗБГЗЗГ-аас шагнал урамшуулал 2000.0 мянган төгрөгийн орлого орж, нийт 67899.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс аймгийн ЗДТГ-ын 2017 оны А/122 дугаар захирамжаар авто замын хяналтын инженерийн цалин шимтгэлийн зардалд 9339.6 мянга, ажилчдад урамшуулалт үйлчилгээнд 2800.0 мянга, автомашины сэлбэг худалдан авалтад 1386.0 мянга, барилга хот байгуулалтын хэлтэст нөөтбүүк, хэвлэх машин худалдан авахад 12274.6 мянган төгрөг, нийт 25800.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 42099.1 мянган төгрөгийг ГЗБГЗЗГ-ын төвлөрүүлэх орлогын дансанд шилжүүлжээ.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 20 мэдээллээс хугацаандаа оруулсан 11 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 6 мэдээлэл, 0 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 521.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 7355.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 23146.4 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 521.1 | 1 | 521.1 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 1 | 7355.0 | 1 | 7355.0 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 3 | 23146.4 | 3 | 23146.4 | 0 | 0 | 0 |
| Нийт дүн | 5 | 31022.5 | 5 | 31022.5 | 0 | 0 | 0 |

Биелэгдээгүй зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн акт байхгүй байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 850.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 850.0 мянган төгрөг, шилэн дансны хугацаа хоцроож мэдээлсэн 6 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх нийт 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар тус байгууллагат зөвлөмжөөс бусад байдлаар залруулагдаагүй алдаа, зөрчил илрээгүй.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 850.0 мянган төгрөг, шилэн дансны хугацаа хоцроосон мэдээлэл алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Тайлант онд батлагдсан төсвийг хэмнэлттэй зарцуулж жилийн төлөвлөгөөг давуулан биелүүлсэн үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч шатахуун, томилолтын зардлаас үр ашиггүй зарцуулсан анхан шатны баримт хангалтгүй зэрэг зөрчлүүд илэрсэн тул тус онд гаргасан алдаа зөрчлийг давтан гаргахгүй буюу өмнөх оны алдаа зөрчлийг дараа онд давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна. Тайлант оныг өмнөх онд гарсан зөрчилтэй харьцуулж үзэхэд шатахууны алдаа зөрчил давтан илэрч байгаа нь анхаарал татахуйц байна. Мөн шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Иймд дараагийн аудитаар анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Томилолтын данстай холбоотой асуудал*

*1.1.* *__Илрүүлэлт:__* Увс аймаг руу зөвлөгөөнд явсан боловч дуудах бичиг байхгүй, гарсан дүн дүн хангалтгүй байна. Томилолт дарга, жолооч 2*70.0 мянган төгрөг авсан.

*1.2.* *__Эрсдэл:__* НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

1.3. *__Өгсөн зөвлөмж:__* НББ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

*1.4.* *__Байгууллагаас өгсөн хариу тайлбар:__* Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

*2. Тээвэр шатахуун холбоотой асуудал*

*__2.1. Илрүүлэлт:__* Увс аймаг руу зөвлөгөөнд явсан боловч дуудах бичиг байхгүй, гарсан үр дүн хангалтгүй 600.0 мянган төгрөгийн шатахууны талон авч, 110.0 мянган төгрөгийг НИК ШТС-руу шилжүүлсэн.

*__2.2. Эрсдэл__*: НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

*__2.3. Өгсөн зөвлөмж__*: НББ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

*__2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:__* Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

*3.Шилэн данстай холбоотой асуудал*

*__3.1. Илрүүлэлт:__* 20 мэдээллээс хугацаандаа оруулсан 11 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 6 мэдээлэл

*__3.2. Эрсдэл__*: НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

*__3.3. Өгсөн зөвлөмж:__* Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;

*__3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:__* Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: 2021 | Аудитын нэр: | ***ГХБХБГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: САГ-2021/5/СТА-ТШ3 |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | **Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар** | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Увс аймаг руу зөвлөгөөнд явсан боловч дуудах бичиг байхгүй, гарсан дүн дүн хангалтгүй байна. Томилолт дарга, жолооч 2*70.0 мянган төгрөг авсан. | 140.0 | Зөвлөмж | Дарга<br>Нягтлан бодогч | Ү.Бямбасүрэн<br>Д.Туяа |
| 2 | Увс аймаг руу зөвлөгөөнд явсан боловч дуудах бичиг байхгүй, гарсан үр дүн хангалтгүй 600.0 мянган төгрөгийн шатахууны талон авч 110.0 мянган төгрөгийг НИК ШТС-руу шилжүүлсэн. | 710.0 | Зөвлөмж | Дарга<br>Нягтлан бодогч | Ү.Бямбасүрэн<br>Д.Туяа |
| 3 | Шилэн данс | 0 | Зөвлөмж | Дарга<br>Нягтлан бодогч | Ү.Бямбасүрэн<br>Д.Туяа |
| **ДҮН** | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР — Ж.ЭНХЦООДОЛ

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР — Б.ЭНХТӨР